



СОЙМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№04 /218/

2022.01.06

Цаг үе, үйл явдал

ЯАМНЫ АВАРГА ШАТАРЧИД ТОДОРЛОО



Монгол Улсад Батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойд зориулсан Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын нэрэмжит "Шатрын аварга баг, тамирчин шалгаруулах тэмцээн" амжилттай болж, өндөрлөлөө.

Энэхүү тэмцээний тэмцээний эрэгтэй төрөлд ахмад А.Одпүрэв /ГХАГ/, дэд хурандаа Б.Нямгэрэл /СБТГ/, хурандаа Д.Содномцог /СБТГ/, эмэгтэй төрөлд кассын нярав Ц.Ганчимэг /СХОХ/, мэргэжилтэн Ж.Амаржаргал /ХШУДАГ/, хурандаа Ч.Нямсүрэн /ГХАГ/ нар шалгарч, алт, мөнгө, хүрэл медалийн эзэд болж шагнал хүрсэн бол багийн дүнгээр Гадаад хамтын ажиллагааны газар 1 дүгээр байр, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар 2 дугаар байр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 3 дугаар байрт шалгарч, шилжин явах цом, алт, мөнгөн медаль, мөнгөн шагналаар тус тус шагнагдсаныг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа өчигдөр гардуулан өгсөн юм.

Түүхэнд энэ өдөр

1914 он.

Өмнөд зүгийн цэргийн бүгд захирагч дарга, шалгарсан баатар, гүн Мурангаагийн захирсан цэргээс 100 цэргийг эргүүлэн татаж, Түшээт ханаймгийн Мэргэн жүн ван Цэсэнжавын хошууны өмнө захад суулгав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,846.0	2,851.0
EUR	3,222.0	3,235.0
CNY	431.00	436.10
RUB	36.38	38.43
JPY	24.70	24.80
KRW	2.37	2.39

ЗУРХАЙ

2022.01.06 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 4/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал: БИЕ ЭРХТНИЙ ХҮЧ САЙЖИРНА НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.41-17.15 БАРИЛДЛАГА: Үл тохирох ШҮТЭН БАРИЛДЛАГА: Нэр өнгө Суудал: Төмөр

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адеуус номхруулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн.

Сахил санаар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.

НОМЫН САНГАА НЭЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн бие бүрэлдэхүүн өөрсдийн дотоод нөөц бололцоогоор номын сангийн байрыг засварлан, шинэчилж 1 дүгээр сарын 5-ны өдөр номын сангийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Номын сангийн нээлтэд ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар болон ангийн удирдлага, алба, салбар хариуцсан дарга нар

оролцсон бөгөөд шинэхэн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, номын сангийн зөвлөл байгуулах, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад зориулсан төрөл бүрийн ажил, үйл ажиллагааг зохион байгуулах тухай санал бодлоо солилцов.

Дэслэгч Р.БИЛЭГ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2.266.225 /69.7%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,164.363 /66.5%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

919.478 28,3%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
7282 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
294

ЭДГЭРСЭН
6872

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 298,096,535

Эдгэрсэн

Нийт: 256,753,221

Нас барсан

Нийт: 5,481,668



Дэд хурандаа Ч.ДАМДИНСҮРЭН

Цахим шууданд

ШИНЭ НОМ

“ЭРДЭМ СУДЛАЛ-2022” МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

СЭДЭВ: “ЭРДЭМ СУДЛАЛ-2022”

Зорилго: Магистрант, докторантууд өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, арга туршлагаа харилцан солилцох боломжийг олгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйд суралцахад оршино.

Илтгэл хүлээн авах хугацаа:

- Илтгэлийг цахимаар 2022 оны 1 дүгээр сарын 10–аас 2 дугаар сарын 11-ний өдрүүдэд хүлээн авна.

Цахимаар хүлээж авах E-mail: Магистрантууд: ch.boldbaatar.63@gmail.com 88286325

Докторантууд: mondoctor@yahoo.com 93115477

Хамрах хүрээ: Магистрант, докторантууд

Хугацаа: “Эрдэм судлал-2022” магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний бага хурал 2022 оны 3 дугаар сарын 04-нд “Сүбээдэй” танхимд болно.

Илтгэлд тавигдах шаардлага: ҮБХИС-ийн стандартын дагуу бичнэ.

- Илтгэл нь эрдэм шинжилгээний ажлын удирдагч, эсвэл тухайн мэргэжлийн чиглэлийн эрдэмтнээр хянуулан баталгаажуулсан байна;

- Өгүүллийн нэр; /12pt өндөртэй үсгээр, мөр хоорондын зай 1 байхаар, тод (Bold), том (Caps Lock) үсгээр голлуулсан бичнэ./

- Зохиогчийн овог, нэр; (12pt өндөртэй үсгээр, налуу (Italic) форматаар мөр голлон бичнэ.

- Хураангуй; /15 мөр, 150-250 үгэнд багтааж бичнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ./

- Түлхүүр үг; /3-5 түлхүүр үг хэрэглэнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ.

- Судалгааны ажлын үндсэн хэсэг /Өгүүллийг Arial фондоор, мөр хоорондын зай 1,15 байхаар, А4 хэмжээний цаасан дээр зүүн гар талаас 30 мм, баруун гар талаас 15 мм, дээд, доод талаас 20 мм-ийн зай авч бичнэ. Өгүүллийг 10 хүртэлх хуудсанд багтаан бичнэ./;

- Дүгнэлт.

- Өгүүлэлд ашигласан эх сурвалжаас заавал эш татна. Эш татсан эх сурвалжийг бичвэрийн холбогдох хэсэгт зүүлт эшлэлийн аргаар (insert footnote) хуудасны доод хэсэгт оруулна. Эшлэлийн эх сурвалжид зохиогч, эх сурвалжийн нэр, хэвлэгдсэн улс, хот, хэвлэгдсэн он, хэвлэгдсэн газар, хэмжээ (хуудасны тоо), хуудасны дугаар/тал, ISBN-ын дугаар зэргийг дэс дараалуулан бичнэ.

АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН АЛБА

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭЛТ АВНА

2021-2022 оны хичээлийн жилд дараах хөтөлбөрөөр суралцагч элсүүлнэ. Үүнд:

Магистрын хөтөлбөр:

1. Хуурай замын цэргийн сургалт
2. Агаарын цэргийн сургалт
3. Кибер аюулгүй байдлын цэргийн сургалт
4. Батлан хамгаалах
5. Цэргийн шинжлэх ухаан
6. Аюулгүй байдал судлал
7. Төрийн удирдлаг

Докторын хөтөлбөр:

1. Батлан хамгаалах
2. Цэргийн шинжлэх ухаан
3. Аюулгүй байдал судлал

Тус сургуулийн магистрын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь бакалаврын зэрэг, докторын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч нь магистрын зэрэг эзэмшсэн байна.

Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид 2022 оны 1 дүгээр сарын 03-аас 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрүүдэд Хичээлийн I дүгээр байр, Ахисан түвшний сургалтын албаны 211 тоотод ирж бүртгүүлнэ үү.

Бүртгүүлэхээр ирэхдээ дараах бичиг, баримтыг авч ирнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- Элсэн суралцах өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Магистрын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын диплом, хавсралтын эх хувийг

нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт, докторын хөтөлбөрт элсэгч нь бакалаврын болон, магистрын диплом, хавсралтын эх хувийг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

- Цээж зураг 2 хувь;
- Бүртгэлийн хураамж 20000 ₮

Элсэлтийн шалгалт: 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хичээлийн I байрны 209, 210 тоот өрөөнд 09.30 цагт эхэлнэ.

Шалгалтын нэгдсэн дүнг 2022 оны 1 дүгээр сарын 27-нд www.mndu.gov.mn сайтад байршуулна.

Магистр, докторын хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгчдээс дараах шалгалтыг авна.

- Мэргэжлийн шалгалт
- Ярилцлага

Харилцах утас, Email хаяг:

Ахисан түвшний сургалтын алба: 86100101, 99092890, 89110773, www.mndu.gov.mn

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУВААРЬ


Магистрын хөтөлбөрт элсэгчдээс:

Д/д	Шалгалт авах чиглэл	Огноо	Цаг	Шалгалт авах хэлбэр	Шалгалт авах газар
1	Мэргэжил	2022.01.20	10.00-11.30	Бичгээр	210 тоот
2	Сэдвийн ярилцлага	2022.01.20	14.00-16.00	Судалгааны сэдвээр бэлдсэн танилцуулга, ярилцлага	210 тоот

Докторын хөтөлбөрт элсэгчдээс:

Д/д	Шалгалт авах чиглэл	Огноо	Цаг	Шалгалт авах хэлбэр	Шалгалт авах газар
1	Мэргэжил	2022.01.20	10.00-11.30	Бичгээр	209 тоот
2	Сэдвийн ярилцлага	2022.01.20	14.00-16.00	Судалгааны сэдвээр бэлдсэн танилцуулга, ярилцлага	209 тоот
3	Нэгдсэн дүн танилцуулах	2022.01.21	14.00	www.mndu.gov.mn .	

“ЦЭРГИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, АРГАЗҮЙН ҮНДЭС” НОМ ХЭВЛЭГДЛЭЭ



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Ph.D), профессор П.Цэдэв цэргийн харилцан ажиллагааны онол, арга зүйн асуудлаар Монголын анхны нэг сэдэвт бие даасан бүтээл болох “Цэргийн харилцан ажиллагааны онол, аргазүйн үндэс” шинэ ном туурвиж, уншигчдын гарт өргөн бариллаа.

Цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж уг бүтээлийг хянан тохиолдуулсан бөгөөд Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн доктор (Sc.D), профессор, О.Үржин, Гавьяат багш, доктор (Ph.D), профессор Б.Түмэн, доктор (Sc.D), профессор Х.Шагдар нар зөвлөхөөр ажиллажээ.

Энэхүү бүтээл нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн, төрлийн цэрэг, нэгтгэл, анги, салбаруудын захирагч /дарга/, штабын офицерууд болоод судалгаа, шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид, ҮБХИС-ийн докторантууд төдийгүй Хил хамгаалах, Дотоодын

цэрэг, Онцгой байдлын байгууллагын удирдлага, анги салбарын захирагч нарын судалгааны ажлын хэрэглэгдэхүүн болгоход зориулагдсан бөгөөд 3 бүлэг, 18 дэд хэсэгтэй, 20.6 хэвлэлийн хуудас тус номд дотоодын 39, гадаадын 54 эх сурвалж, судалгааны бүтээлийг ашигласан байна.

Судлаач “Цэргийн харилцан ажиллагааны онол үндэс” хэмээх нэгдүгээр бүлэгтээ цэргийн харилцан ажиллагааны онолын асуудал, харилцан ажиллагааны зүй тогтол, зарчим, мөн чанар, зорилго, тавигдах шаардлага болон харилцан ажиллагааны удирдлагын түвшин, хэлбэр, арга, ердийн зэвсэг хэрэглэсэн байлдаанд давших операцийн цэргийн харилцан ажиллагаа, байлдааны ажиллагааны бүтэмж нь зэвсэг, байлдааны техник, ар талаас хамаарах нь зэрэг асуудлыг шинжлэх ухааны талаас нь судалж оруулсан бол “Дайны үеийн цэргийн харилцан ажиллагааны зарим туршлага, сургамж” хэмээх хоёрдугаар бүлэгтээ XIII-XIV зууны Монголчуудын аян дайны үеийн цэргийн харилцан ажиллагаа, XVII зууны эцэс, XVIII зуунд болсон зарим дайн, байлдааны үеийн

харилцан ажиллагаа, Исмаил цайзын бүслэлт, дайралтын харилцан ажиллагаа, Дэлхийн хоёрдугаар дайны үеийн зарим томоохон операцийн цэргийн харилцан ажиллагаа, АНУ, Англи, Япон, Германы арми, Орон нутгийн дайны харилцан ажиллагааны тоймоос оруулсан байна.

Түүнчлэн “Цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулах арга зүйн үндэс”-ийг тодорхойлсон гуравдугаар бүлэгтээ цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулах үндэс, зарчим, арга барилуудыг ашиглах, Ерөнхий цэргийн байлдааны явцад харилцан ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, хориглох, давших байлдааны үеийн харилцан ажиллагааны асуудлыг хөнджээ. Цэргийн харилцан ажиллагааны онолын асуудлыг ухагдахуун, мөн чанар, зүй тогтол, зарчим, тавигдах шаардлага, удирдлагын түвшинд судалж, дайны үеийн цэргийн харилцан ажиллагааны зарим туршлага сургамжийг нэгтгэн, цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулах арга зүйн үндсийг боловсруулан гаргасан онол, практикийн ач холбогдолтой энэхүү бүтээл сонирхогч, судлаачдын талархлыг хүлээх нь дамжиггүй.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

Гэрэл зургийн дуранд



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн хугацаат цэргийн алба хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Гар барилдааны аварга”, “Гар дээр суниалт”, “Шатар”-ын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион явуулж аваргууддаа шалгарууллаа.